

ДАРХАН УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Эмтнаран" ОНӨААТҮГ-ын 2023 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/06/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.Shinjenmagadlahui.ezshaudit.mn Улаанбаатар хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjenmagadlahui.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН
“ЭМТ НАРАН” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Л.ЯНЖИНДУЛАМ ТАНАА

Ауды 03.15 № 157
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол тус газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 50,118.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлаас давсан нь дангаараа болон эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5, Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, 84 дүгээр зүйлийн 84.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ нь тайлант онд 746,268.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,136,732.2 мянган төгрөгийн зардал гарган 390,464.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ нь тайлант 2023 онд хэрэгжүүлэх зорилтот түвшний төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн зорилтот түвшний гүйцэтгэл 114,3 хувийн биелэлттэй байна.

009020276

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Хонгор сумын “Эмт наран” ОНӨААТҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 86.0 хувиар тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөгөөр/	
Д/д	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31		
1	ХӨРӨНГӨ				
1.1	Эргэлтийн хөрөнгө				
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	34,946,371.27	16,993,332.62		
1.1.2	Дансны авлага	53,555,741.97	37,915,124.92		
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	664,587.08	606,333.02		
1.1.4	Бусад авлага	-			
1.1.6	Бараа материал	72,768,083.67	60,357,067.3		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	161,934,783.99	115,871,857.86		
1.2	Эргэлтийн бус хөрөнгө				
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,126,596,802.18	2,719,982,027.50		
1.2.2	Биет бус хөрөнгө	191,834,000.17	192,713,000.17		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,218,430,802.35	2,912,695,027.67		
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,480,365,586.34	3,028,566,885.53		
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
2.1	Өр төлбөр				
2.1.1	Богино хугацаат өр төлбөр				
2.1.1.1	Дансны өглөг	2,533,428.15	15,245,160.14		
2.1.1.3	Татварын өр	66,105,582.75	81,934,672.46		
2.1.1.5	Богино хугацаат зээл				
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр				
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	68,639,010.90	97,179,832.60		
2.1.2	Урт хугацаат өр төлбөр				
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр				
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн				
2.2	Өр төлбөрийн нийт дүн	68,639,010.90	97,179,832.60		
2.3	Эздийн өмч				
2.3.1	Өмч: - төрийн	945,252,479.20	945,252,479.20		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	664,681,823.03	664,681,823.03		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,124,194,606.54	3,034,319,607.44		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,322,402,333.33)	(1,712,866,856.74)		
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,411,726,575.44	2,931,387,052.93		
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,480,365,586.34	3,028,566,885.53		

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

				/төгрөгөөр/	
Д/д	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31		
1	Борлуулалтын орлого (цэвэр)	484,580,092.72	516,850,210.26		
2	Борлуулалтын өртөг	214,586,002.61	273,255,659.78		
3	Нийт ашиг (алдагдал)	269,994,090.11	243,594,550.48		
4	Санхүүгийн дэмждэг орлого		184,765,454.55		
8	Бусад орлого	205,469,641.82	44,652,429.10		
9	Борлуулалт маркетингийн зардал				

10	Ерөнхий ба удирдлагын зардал	755,465,923.12	863,386,083.54
11	Санхүүгийн зардал	104,700.00	90,874.00
12	Бусад зардал		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(280,106,891.19)	(390,464,523.41)
19	Орлогын татварын зардал	(280,106,891.19)	(390,464,523.41)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(280,106,891.19)	((390,464,523.41))
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(280,106,891.19)	(390,464,523.41)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	2,124,194,606.54	(1,322,402,333.33)	2,411,726,575.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	2,124,194,606.54	(1,322,402,333.33)	2,411,726,575.44
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	2,124,194,606.54	(1,322,402,333.33)	2,411,726,575.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					

Залруулсан үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	2,124,194,606.54	(1,322,402,333.33)	2,411,726,575.44
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(390,464,523.41)	(390,464,523.41)
Бусад дэлгэрэн гүй орлого			910,125,000.90		910,125,000.90
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	945,252,479.20	664,681,823.03	3,034,319,607.44	(1,712,866,856.71)	2,931,387,052.93

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31	2023.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	795,133,543.43	824,389,381.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	541,652,663.43	571,134,940.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	144,428,600.00	203,242,000.00
	Бусад мөнгөн орлого	109,052,280.00	50,012,441.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	802,524,630.47	841,642,419.65
	Ажиллагчдад төлсөн	260,016,114.02	308,077,742.87
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	84,221,724.13	101,736,870.55
	Бараа материал худалдан авахад төлсөн	233,081,855.00	197,895,517.66
	Ашиглалтын зардалд төлсөн	72,839,038.47	115,734,291.90
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,175,900.00	19,824,692.92
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	56,349,413.95	60,914,908.75
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	76,840,584.90	37,458,395.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,391,087.04)	(17,253,038.65)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,595,000.00	700,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,595,000.00	700,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,595,000.00	700,000.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(20,986,087.04)	(17,953,038.65)

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,932,458.31	34,946,371.27
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,946,371.27	16,993,332.62

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Дулааны борлуулалт	417,600.00	420,991.09	3,391.09	100.81
	Усны орлого	68,497.50	95,859.12	27,361.62	139.95
	Татаас, санхүүжилт /НӨАТ хассан дүн/	122,038.18	184,765.45	62,727.27	151.40
	Бусад орлого	44,571.40	44,652.43	81.03	100.18
	Нийт орлого	652,707.08	746,268.09	93,561.01	114.33
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	140,000.00	134,145.01	(5,854.99)	(95.82)
	Банкны шимтгэл	120.00	90.87	(29.13)	75.72
	Үндсэн цалин	406,074.00	393,383.71	(12,690.29)	(96.87)
	1 удаагын тэтгэмж болон бусад	4,200.00	2,477.40	(1,722.60)	58.98
	ХЧТүр алдсны тэтгэмж	1,500.00	0.00	(1,500.00)	(00.00)
	НДШ-ийн зардал	58,068.60	57,495.88	(572.72)	(99.01)
	Багаж техник, Засвар, үйлчилгээний зардал	26,000.00	39,508.03	13,508.03	151.95
	Шинжилгээний зардал	2,500.00	1,233.40	(1,266.60)	(49.34)
	Гэрэл цахилгааны зардал	85,000.00	102,458.45	17,458.45	120.54
	Зам ашиглалт зардал	3,000.00	3,200.00	200.00	106.67
	Интернет, шуудан холбоо	1,080.00	1,369.27	289.27	126.78
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	9,450.00	8,905.71	(544.29)	(94.24)
	Сургалтын зардал	3,000.00	1,360.00	(1,640.00)	(45.33)
	Нормын сүүний зардал	2,000.00	1,851.70	(148.30)	(92.58)
	Дотоод томилолтын зардал	1,000.00	376.00	(624.00)	(37.60)
	Ахмадын хүндэтгэл	300.00	390.00	90.00	130.00
	Тээврийн зардал /ковшийн түрээс/	6,000.00	8,032.35	2,032.35	133.87
	Элэгдлийн зардал	280,000.00	312,550.60	32,550.60	111.63
	Шатахууны зардал	19,500.00	19,529.73	29.73	100.15
	Үйл ажиллагааны бусад зардал	15,500.00	29,618.82	14,118.82	191.09
	Бичиг хэргийн зардал	1,300.00	1,213.58	86.42	(93.35)
	Вагон ашиглалтын зардал+ Вагон тээвэр	4,450.00	3,327.80	(1,122.20)	(74.78)
	Тээврийн хэрэгслийн татвар, оншилгоо зардал	1,000.00	687.93	(312.08)	(68.79)
	Үл хөдлөх хөрөнгийн татварын зардал	1,585.00	1,370.88	(214.12)	(86.49)
	Газрын төлбөр	1,000.00	1,631.98	631.98	163.20
	Ус, рашаан ашигласны татвар	1,584.50	1,321.13	(263.37)	(83.38)
	Хөдөлмөр хамгааллын зардал	12,000.00	9,202.41	2,797.59	(76.68)
Зардлын дүн	1,087,212.00	1,136,733.00	(49,520.52)	104.55	
Ашиг/ алдагдал/	(434,505.0)	(390,465.0)	(4,404.49)	(89.86)	

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 259,465.0 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил² илэрснийг аудитын явцад 209,346.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 575.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 49,542.8 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

УТХО, ОНХС-ийн хөрөнгөөр ирсэн үндсэн хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн ангилал буруу бүртгэснээс 209,346.6 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан 1 дүгээр хавсралт “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулыг бэлтгэх заавар” болон НББОУС 16 Үндсэн хөрөнгийг мөрдөх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу үндсэн хөрөнгө залруулав.

5.1 Төлбөрийн акт

1. Инженер Л.Янжинлхамыг бичиг хэргийн ажилтанг ажлыг хавсран гүйцэтгүүлж, нэмэгдэл хөлсийг инженерийн цалингаас тооцож 575.6 мянган төгрөгийг 2023 оны 01 дүгээр сарын 16-ны А/03 дугаар тушаалаар МУ-ын ТБОНӨТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Хөдөлмөрийн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дах хэсэг, 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг үндэслэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалин хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төсөвт төлөх татварын өр хуримтлагдаж, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхөөр байгаа, мөн санхүү төсвийг зүй зохистой удирдаагүйгээс Өр төлбөр 28,540.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Татварын ерөнхий хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д "Дараах үйлдэл, эс үйлдлийн улмаас төсөвт төлөх татварын хэмжээг бууруулсан буюу төлөөгүй бол төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын дүнгийн 40 хувиар торгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, өр төлбөрийг бууруулах

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Цасны баяр, тэмцээн наадмын арга хэмжээ зохион байгуулахад бооцооны мөнгө, хоол, хүнсэнд 1,185.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, " Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" зэрэг заалтуудыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Эмтнаран" ОНӨААТҮГ-ын хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж байх.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Бараа материалын худалдан авалт, түлш шатахууны орлогын баримтыг тоо хэмжээ, нэг бүрийн үнээр бичээгүй бөөн дүнгээр бичсэн, автомашины шатахуун зарцуулалтын норм тогтоогоогүй, жолоочийн тооцоо бодоогүй, зардлыг тооцооллын дагуу бодитоор зардалд тусгаж баталгаажуулаагүй 16,437.0 мянган төгрөг тайлагнасан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтын нөхөх заавар"-ын 3. Бараа материалын үнэт зүйлийн маягтыг нөхөх зааврын 2. Орлогын баримт НХМаягт БМ-2 маягт хөтлөөгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" зэрэг заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Бараа материал дансанд шатахууныг орлого авахдаа орлогын баримтад нэг бүрийн үнэ тоо хэмжээгээр бичиж, жолоочийн тооцоог сар бүр бодож хэвших.

4. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Тайлант онд 3,380.0 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий

төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн	1	209,346.6			1	209,346.6	1	209,346.6				
Дүн	1	209,346.6			1	209,346.6	1	209,346.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			Тоо	Дүн
хавсран ажилласны нэмэгдлийг илүү олгосон	1	575.6	1	575.6								
өр төлбөр үүсгэсэн	1	28,540.8					1	28,540.8				
Цасны баяр, тэмцээн наадмын арга хэмжээ зохион байгуулахад бооцооны мөнгө, хоол, хүнсэнд	1	1,185.0					1	1,185.0				
түлш шатахууны орлогын баримтыг тоо хэмжээ, нэг	1	16,437.0					1	16,437.0				

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

бүрийн үнээр бичээгүй бөөн дүнгээр бичсэн, Автомашины шатахуун зарцуулалтын норм тогтоогоогүй, жолоочийн тооцоо бодоогүй												
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	3,380.0					1	3,380.0				
Дүн	5	50,118.4	1	575.6			4	49,542.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 30,853.5 мянган төгрөгийн 2 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.	1	30,853.5					1	30,853.5
Дүн	1	30,853.5					1	30,853.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа харьцуулалтын арга хэрэглээгүй	1	128,790.9					1	128,790.9
	1	128,790.9					1	128,790.9
Дүн	2	159,644.4					2	159,644.4

